

## Сургуулийн өдөр өнжүүлэх ба сургуулийн клуб

**6.00 – 17.00 цагт ажиллана**

### „Өглөө“

**Өглөө 6.00- 7.40 цагт** онгойно (хүүхдийн хичээл 9.00 цагт эхэлдэг бол өдөр өнжүүлэхэд 8.45 цагт хүүхдүүд ирсэн байна).

Өглөөний өдөр өнжүүлэхэд явдаг хүүхдүүд 7.30 цагийн дотор ирсэн байна. Өдөр өнжүүлэхийн багш нар бэлтгэл ангийн ба нэгдүгээр ангийн хүүхдүүдийг хүргэж өгнө, том хүүхдүүдийг ангийн хувцасны өрөөнд хүргэж өгнө.

### Үдээс хойш өдөр өнжүүлэх

Хичээл дууссангуут өдөр өнжүүлэхийн багш ангиас хүүхдүүдээ хүлээн авна. Бүгд сургуулийн өдөр өнжүүлэх танхимд цугларна ( III байр.), энд хүүхдүүд цүнхээ тавина дараа нь өдрийн хоолонд орно. Заримдаа шууд сургуулийн хоолны газраас хувцасны өрөө лүү шууд явна. Өдрийн хоолны дараа гадаах үйл ажиллагаа, амрах үйл ажиллагаа, гадаа тоглох, нийтлэг боловсрол, чөлөөт цаг, сонирхолтой үйл ажиллагаа, амралт чөлөөт цагийн үйл ажиллагааг явуулна. Хүүхдүүдийн энэ идэвхтэй ажиллагааг тасалдуулахгүйн тулд хүүхдүүдээ өдрийн хоолны дараа авах эсвэл 14.30 хойш авах цагаа сонго. 15 цагаас хойш бол хүүхдүүд бас өөр сонирхолтой үйл ажиллагаа хийж байгаа учир хүүхдүүд багаараа ажилладаг эсвэл дугуйланд явдаг.

### Дуусах

Үлдсэн хүүхдүүд өдөр өнжүүлэх дуусах хугацаа дууссаны дараа өдөр өнжүүлэх ангиуд нь нэг анги руу шилжин орно.

**Таны хүүхэд ямар тасагт өглөө хамаарагдах нь гол хаалганы эсрэг талын самбар дээр бичээстэй байгаа. Та өөрийнхөө хүүхдийн явдаг тасгийн тоог мэддэг байх ёстой.**

### Сануулах:

1. Өдрийн хоолыг эцэг эх төлнө, хоолыг бас эцэг эх өөрсдөө хасуулна. Хүүхдийн өдрийн хоолыг гэртээ сонгоно. Цайны газраас нууц код өгнө. Хоолны төлбөрийг сар бүрийн 25-ны дотор төлсөн байх шаардлагатай.
2. Харилцах дэвтэр дээр бич, хүүхэд өдөр өнжүүлэхэд хэзээ ирэх ба явах цагийн хуваарь, өөрөө гэрүүгээ явах, хэзээ хаашаа явах (дугуйлан, гэрүүгээ...) жишээ нь., хэн ирж авах /харилцах дэвтрийн ар талд байгаа/. Энэ харилцах дэвтрийг сургууль эхлэхэд өдөр өнжүүлэхийн багшаас авна.
3. Өөрийн хүүхдийн бүх өөрчлөлтийг нь харилцах дэвтэр ба өөрийн биеэр ирж өдөр өнжүүлэхийн багшид мэдээлэх ёстой.
4. Хэрвээ хүүхэд тогтмол өдөр өнжүүлэхэд явдаг бол сарын төлбөр нь 350 крон. Хэрэв хүүхэд тогтмол биш явдаг, эсвэл зөвхөн өглөө ирдэг бол сарын төлбөр нь 110 крон. Хэрэв зөвхөн хагас цаг явдаг бол төлбөр төлөхгүй. Төлбөрийг заавал дансаар шилжүүлнэ, төлбөрийг **сар бүрийн 15 өдрийн дотор төлсөн байна. !!!!! 2023 оны 9-р сараас 2024 оны 6-р сар хоолны төлбөрийг банкаар тогтмол данснаасаа төлүүлэх эрхийг өг.**

**ЭРГҮҮЛ!**

5. Дансны дугаар **17132421**, банкны дугаар **0100**, var. Symbol = таних тэмдэг- **хүүхдийн регистрийн дугаар**, хүлээн авах мэдээн дээр – **хүүхдийн овог нэрийг заавал бич- ЧУХАЛ!!!!!!!!!!!!**

**Энэ хүүхдийн регистрийн дугаарыг сургууль эхлэхэд ангийн хурал дээр ангийн багшаас хүүхдэд нууц код өгнө.**

Төлбөрийг **сар бүр**, хуанлийн **жилийн эцэс** хүртэл / **1 400 крон** /, **нэгдүгээр сараас** хичээлийн **жилийн эцэс** хүртэл / **2 100 крон** / хийх боломжтой.

Та тэмдэглэлийн дэвтэрт бүх мэдээллийг үргэлж хадгалах болно. Хэрэв танд ямар нэг асуулт байвал сургалтын багш нартай холбоо барьж нэмэлт мэдээлэл өгөх болно.

Бүх мэдээлэл харилцах дэвтэр дээр байна. Ямар нэгэн асуулт байвал өдөр өнжүүлэхийн багшаас асууж болно.